

## 1970 оны есдүгээр сарын нэгэнд АНУ-ын ерөнхийлөгч Т.Рузьвельт Монголын тухай нэгэн номд бичсэн өмнөтгөл

Оршил болон өгүүлэхүй

Америкийн шилдэг цөөхөн эрдэмтдийн нэг Жеремиах Куртин нас барсан нь улс оронд маань хүнд гарз болсон билээ. Куртин нь Висконсон мужийн уугуул бөгөөд нэгэн цагт Засгийн газрын дипломат албанд зүтгэж явсан ч утга зохиолд гол анхаарлаа хандуулан ажиллаж байлаа. Түүний хэл сурах гайхалтай авъяас, эх хэлээ төгс эзэмшсэн чадвар, цуцашгүй зүтгэл, цаг наргүй хөдөлмөр, харь улс үндэстнүүд өвөрмөц онцлог бүхий ард түмний тухай бүхнийг мэдэх гэсэн чин эрмэлзэл, чухал үйл явдлуудын ач холбогдлыг үнэлж, анхааран судлахад суурь болсон түүхийн уран сэтгэмжийн ер бусын авъяас нь түүний зохиол бүтээлүүдийг нэн өвөрмөц өнгө аястай болгосон юм. Тэрбээр Польшийн зохиолч Сенкевичийн бүтээлээс орчуулсны дотор дундад зууны үеийн Польшийн Татар, Швед, Германтай хийсэн тэмцлийг өгүүлсэн түүх нь дангаараа гэхэд л хэнд ч алдар хүндийг авчрах гайхамшигт бүтээлүүд байв. Куртин Энэтхэг, Кельт болон бусад ард түмний аман зохиолын холбогдолтой алдарт бүтээлүүд олныг туурвисан ч аугаа Монголын эзэнт гүрний мандал буурлын үеийн судалгааны бүтээл нь онцгой ач холбогдолтой бөгөөд энэхүү салбарт Америк, Английн эрдэмтдээс түүнд дөхөж очсон хүн гараагүй юм.

Улс үндэстнийг донсолгон бутаргасан Монголын байлдан дагуулал дэлхийн түүхэнд эзлэх нэн үлэмж учир холбогдолтойг Америк, Английн тэргүүлэх эрдэмтэд төдийлөн хайхардаггүй нь тун хачирхалтай. Хэдхэн жилийн өмнө Английн нэгэн алдарт зохиогч *Арвангуравдугаар зуун*-д сонирхолтой өгүүлэл нийтлүүлсэн бөгөөд түүнээс зохиогчийн гүнзгий мэдлэг, түүхэн үйл явдлуудын ойлголт, тухайн зуунд холбогдох судалгаан дээр нилээд ажилласан нь уул өгүүллээс харагдаж байв. Гэвч тэрбээр тухайн цаг үеийн хамгийн онцлог үйл явдал болох Чингис хааны хүчирхэгжилт болон Шар тэнгисээс Адриатын тэнгис, Персийн булан хүртэлх Монголын ноёрхлыг огтхон ч дурдалгүй орхисон байж билээ.

Түүх бол зөвхөн Европын түүх, Европын түүх нь зөвхөн Латин болон Тевтоны Европын түүх гэдэг өрнөд Европыг дөвийлгөгч үзэлтэй хүмүүсийн нийтлэг хандлага нь зарим талаар энэ мэт санаатай үл хэрэгсэх шалтгаан болох нь бий. Гэхдээ энэ нь удаа дараагийн загалмайтны аян дайнтай зүйрлэшгүйгээр Европын тэн хагаст нөлөөлсөн Монгол-Татарын булаан эзлэлт шиг түүхэн үйл явдлыг үл хайхрах шалтаг болж чадахгүй юм.

Голдуу мэдлэг нимгэн хүмүүс ийн аашлах нь аргагүй бөгөөд тэртээ Саламины тулалдаанаас хойш Европыг буулган авсан Азийн анхны дайн болох Япон Оросын дайны үеэр чухам энэхүү үл ойшоох хэнэггүй байдал нь тэднийг хөгөө чирэхэд хүргэсэн нь лавтай.

Үнэндээ цагаан арьстны буюу европ угсаатны сүүлийн үеийн цэргийн ноёрхол нь гурван зууны төдий л хэрэг юм. Үүнээс өмнөх дөрвөн зууны туршид буюу арвангурваас арвандолоодугаар зуун хүртэлх бүхий л хугацаанд Монгол Түрэгийн армиуд нь Европын дайчидтай хийсэн ямар ч тулалдаанд илтэд давамгайлж Европт байнгын булаан эзлэгч, байлдан дагуулагчаар тодорч байсан бол тэр үеийн европын ямар ч удирдагч Чингис хаан, Төмөр хаан, Баязет, Селим, Мурад, Бабур, Акбар нар шиг асар хүчирхэг цэрэг арми, аугаа ялалтын алдар хүртэж чадаагүй юм. Монголыг Чингис хааны удирдлага дор тийн хүчирхэгжин босч ирнэ хэмээн хэн ч санаагүй бөгөөд энэ нь дэлхий дахиныг зургаан зууны өмнөх Арабын хүчирхэгжилт шиг алмайруулсан билээ. Арвануравдугаар зууны эхээр Чингис хаан эгэл бусад удирдагч нарын нэг байсан ба түүнийг болон овог

аймгийнхныг нь мал сүргээ адуулан аж төрдөг төв Азийн онгон дагшин тал нутгийнхнаас өөр хэн ч мэддэггүй байлаа.

Жишээлбэл, өнөөгийн соёл ирэншилт нийгэм Сенүс юм уу эсвэл хүн болгоны мэддэггүй хар махдиг мэддэг хаа байсан Сахарын өмнөд хэсэгт мэддэг, эмээдэг хэн ч байгаагүй ажээ.

Тухайн тэр үед Европ нь Ази буюу Африкийн аль алиных нь түрэмгийллээс айхаа больсон байлаа. Испанид мавруудын хүч нь ихээхэн буурч төдийлэн аюултай бус болсон байв.

Загалмайтны уршигт Дөрөвдүгээр аян дайнаар франкчууд ба венецчүүд Константинополийг эзлэн авч буруу номтны эсрэг Европын бэхлэлтийг устгасаж аян дайны сүр сүлдийг бүхэлд нь унагажээ.

Эзэн хаан Барбаросса өмнөх аян дайнд өөрийн амиа үрэн байж Бага ази дахь сэлжук түрэгүүдийн хүчийг бүрэн доройтуулсан байв. Гэвч Иерусалимыг алдчихаад байсныг ертөнцийн гайхамшиг хэмээгдэх эзэн хаан II Фридрих эргүүлэн авахаар зэхэж байлаа.

Оросын Славчуудын нэгдэл нягтрал нь сулхан байсан бөгөөд дорно зүг аажимхан тэлж олон янзын финчүүдийн дунд Москва адил суурин байгуулж байв. Унгар Польш хоёр сүрхий дайнч улс байсан авч Польш нь бүрэн хүчирхэгжихэд хоёр зуун дутуу байлаа. Халифууд Багдадад хаанчилсан хэвээр байв. Энэтхэгт лалууд ражпуттай байлдав. Хятадын хаант улс нь соёл иргэншил болон цэргийн хүчний хувьд Европын ямар ч улс орноос илт давуу байлаа.

Ертөнц дахин ийм байхад монголчууд цахиур хагалан орж ирсэн юм. Чингис хаан эхний хэдэн жилд өөрийн овог аймгийг нэгтгэн захирч дараагаар нь буюу арвангуравдугаар зууны эхний арван жилд хөрш зэргэлдээ бүх овог аймгуудад өөрийн бүрэн ноёрхлоо тогтоосон бөгөөд тэрбээр ийнхүү талын морьтон эрсийг атгаж чадсан нь үнэхээр хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй зүйл байлаа. Хүсэл зоригийг нь сөрсөн, үг дуугүй толгой бөхийлгөн дагаагүй хүн бүхнийг тэрбээр ямар ч өршөөлгүйгээр хороож байсан бөгөөд өөрт нь үнэнчээр зүтгэж зарлиг тушаал бүхнийг нь өчүүхэн ч түдгэлзэлгүй биелүүлэхэд бэлэн байж чаддаг олон дайчдаар хүрээлүүлсэн юм.

Чингис хаан бээр хамгийн шилдэг морьт харваачид болон морьтон дайчид дундаас өөрийн эрэлхэг баатруудаа нэн түргэн бүрдүүлж өрнө, дорно, өмнөд рүү илгээж байлаа. Түүний болон ойрын залгамжлагчдынх нь удирдлагаар эзлэн авсан газар нутаг маш түргэн хугацаанд өргөжин тэлж байсан юм. Энэ зуур Ази, Европт тэдгээр бэрх монгол морьтон дайчид болон тэдний хамтрагч, холын төрөл бөгөөд, тэдэнд зүтгэж явсан түрэг татаруудтай эн тэнцэхүйц цэргүүдтэй болох хүртэл хоёр үе өнгөрсөн байдаг.

Хүн төрөлхтний түүхэнд туйлын аймшигт хор уршиг дагуулсан булаан эзлэлт ховор байсан билээ. Монголчууд хэдий чинээ мятрашгүй хатуу, эрэлхэг зоригтой шигээ төдий чинээ аймшигтай түрэмгий байлаа. Тухайн үед Азийн нилээд нутагт тархсан историан загалмайтнууд монголчуудын дунд байсан ч ихэнх нь арванесдүгээр зууны Хойт Америкийн уугуул иргэдийн Команчи ба Апачи хэмээх овог аймгуудтай төстэй итгэл үнэмшил, зан заншилтай бөөгийн шашинтнууд байв. Тэд өөрсдөд нь хэдий ашигтай боловч бусдад нэн аймшигтай байдлыг авчирсан цэрэг дайны зохион байгуулалт, хүчин чадлаараа дээрх хоёр аймгаас ялгарч байв. Монголчуудын ноёрхолд өртсөн улсууд нь хэрэв өнөө үеийн соёл иргэншилт хүмүүс гэнэт Апачигийн нүүдлийн овог аймгуудад эзлэгдвээс ямар байхтай адил аймшигтай хувь зохиол амссан билээ. Урьд хожид хэзээ ч байгаагүй хайр найргүй хэрцгийллийг монголчууд үйлдсэн юм. Лалууд болон загалмайтнууд тэднийг нэгэнтээ сандаргасан боловч монголчууд халифийг нь хороож, Орос, Унгарын хотуудыг тонон Багдадыг ч мөн адил цөлмөжээ. Тэд Европын эсэргүүцэгч бүхнийг залхаан цээрлүүлсэн шигээ өөрсдийг нь сөрж зүрхэлсэн түрэгүүдийг ямар ч өршөөлгүй хядсан билээ. Монголчууд нь тулалдаанд нэн гарамгай, олон хоногийн аянд цуцдаггүй, элдэв хямрал, хүнд хэцүү нөхцөл байдалд огт үл ажрах бөгөөд нум сум, илдийг

хэнээс ч илүү гарамгайгаар эзэмшсэн байв. Айдаст автсан Европынхонд намхан, бахим чийрэг биетэй, онигор нүдтэй, “нохойн хоншоор шиг нүүртэй” тэдгээр морьтнууд муу ёрын сүнс мэт туйлын аймшигтай, тэднийг эсэргүүцэн босох нь эгэл жирийн хүмүүсийн хувьд ямар ч боломжгүй мэт санагдаж байлаа. Монголчууд Хятадыг эзлэн аваад хаан суурин дээр нь Монголын эзэнт гүрнийг байгуулжээ. Тэд бас Энэтхэгийг эзлэн авч Их Могол улсыг байгуулсан бөгөөд Перс ч мөн адил тэдний гарт орсон юм. Монголчуудын арми, морьтон цэрэгүүд нь итгэмээргүй хол газар аялан дайтах бөгөөд өөрсдийг нь эсэргүүцсэн болгоныг замаасаа арчин хаяж байв. Тэд Оросуудыг ганц дайралтаар бут цохиж газар нутгийг нь морьдын туурайн дор цусан балчиг болтол талхалжээ. Мажаруудыг мөн ганцхан тулалдаанаар буулган авч хүн амын талыг нь хүйс тэмтэрсэн бөгөөд Унгерын хаан нь эзэнт улсаа орхин ут хумгүй зугтжээ. Польшийг эзэлж, Умард Германы шигшмэл дайчдыг Силезд бут ниргэв. Баруун Европ тэдний эсрэг дорвитой зүйл хийж чадахааргүй байсан бөгөөд аз болоход тэр үед монголчуудын дайралт эх нутгаасаа хэт холдсоноос шалтгаалан зогссон юм. Энэ нь монголчуудын булаан эзлэлтийг эхэндээ цэргийн хүчээр түр торгоосон загалмайтны юмуу Европын цэргийн хүч эсвэл өрнөдөд Египетийн Түрэгийн Мамлукүүд, дорно зүгт дөчөөд жилийн дараах Японы армийн алинаас нь ч шалтгаалсан хэрэг бус байлаа.

Үүнээс хоёр үе өнгөрөхөд Дорнодын Монголчууд нь буддын, Өрнөдийнхөн нь лалын шашинтан болжээ. Өрнөдөд жинхэнэ монголчууд нь булаан эзлэж байлдан дагуулж явсан Түрэг аймгууддаа аажмаар уусан алга болов. Эдгээр түрэг аймгууд нь Оросыг хоёр зууны турш туйлын харгисаар цус урсган боолчилсон мөнөөх татарууд бөгөөд энэ нь үндэстний сэтгэл зүрхэнд гүнзгий шарх үлдээсэн юм. Османы Түрэгүүд Константинополийг эзлэн авснаас хойш гуч гаруй жил өнгөрөх хүртэл Оросууд энэхүү ёс бус дарлалыг таягдан хаяж чадаагүй бөгөөд османууд хүчирхэгжих тусам татаруудын хүч нь суларч байв. Польш сэргэн хөгжиж Балтийн тэнгисээс Хар тэнгис хүртэлх асар уудам газар нутгийг эзлэн оршиж байсан нь османуудад Оросоос илүү чухал ач холбогдолтой байлаа.

Олонтаа хэрэн аялсан Элизабетан, Финнэс Моррисон нарын “Аян замын тэмдэглэл” зохиолд Түрэгүүд нь Унгерыг эзлэн авснаас хойш Польшийг Герман болон ямар ч улсаас илүүгээр айлган түгшээж байсныг дурдсан байдаг.

Монголчуудын эзлэн түрэмгийлэл нь хүрсэн газар болгондоо дааж давшгүй зовлон гамшиг дагуулж урт удаан хугацааны хар дурсамж бөгөөд үлдээсэн бөгөөд саяхан болтол зүүн Европын зарим сүмийн мөргөл нь “эрхэм эзэн минь биднийг монголчуудын аюул заналаас гэтэлгэж хайрла” гэсэн үгтэй байв. Монголчуудын арми шоргоолж зөгий мэт нэгдмэл хүчийг бий болгосноор удирдагч нь хэн бэ гэдгээс үл хамааран дайснаа ялах боломжийг тэдэнд олгосон юм. Францын нэгэн зохиогч Монголчуудын алдарт “нэргүй ялалтууд”-г Түрэгийн догшин байлдан дагуулагч, бидний мэддэгээр Татар Төмөр буюу Төмөр хааны амжилт ялалтуудтай сайтар харьцуулан бичсэн байдаг. Эзлэн авчноёрхлоо тогтоосон газар нутаг бүхэндээ Монголчууд талаар авч явуулсан бодлого нь Хятадаас санаа авсан иргэний зохицуулалтын нүсэр бодлогыг хэрэгжүүлсэн нь тухайн ард олонд хүндээр тусч монгол цэргүүд хэдий чинээ балмад авирлан дураар харгислал үйлдэн, төдий чинээ дургүйцлийг төрүүлж байжээ. Монголчуудын эзэнт гүрэн аажмаар задран мөхөж бусад улс оронд шууд нөлөөтэй хэвээр үлдэж чадаагүй юм. Гэвч энэ нь Монголчуудын түүхийг бүрэн судлаж мэдэхгүйгээр Ази болон зүүн Европын түүхийг ойлгож ухаарах аргагүйд хүргэсэн аугаа түүхэн үйл явдал байсан бөгөөд англи хэлээр бүтээлээ туурвидаг өөр ямар ч зохиогч энэхүү түүхийг Жеремиах Куртин шиг гайхамшигтай сайхан өгүүлж чадаагүй билээ.

Теодор Рувельт  
Сагамор Хилл, 1907 оны есдүгээр сарын 1